БАТЛАВ.

ЗАСАГ ДАРГА О.ПҮРЭВДОРЖ

2025 оны 19 дүгаар сарын 30

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХУЖИРТ СУМЫН ШИВЭЭТ 4 ДҮГЭЭР БАГ, ШУНХЛАЙ 5 ДУГААР БАГУУДАД ШИНЭЭР ХИЙХ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

АРВАЙХЭЭР

2025 он

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

Тендер шалгаруулалтын нэр:	*Өвөрхангай аймгийн Хужирт сумын Шивээт 4 дүгээр баг, Шунхлай 5 дугаар багуудад шинээр хийх хатуу хучилттай авто замын нарийвчилсан зураг төсөл боловсруулах*
Тендер шалгаруулалтын дугаар:	*ӨВАХААГ/20260203034*

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

ендерийн цар хүрээ

өрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "**Хууль**" гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид "**үйлчилгээ**" гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна.

ендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.

ендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.

уулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.

гөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол хуулийн 11.9-д зааснаар ажлын үр дүнд бий болох оюуны өмчийн эрхийг захиалагч, түүний нэр заасан этгээд эзэмшинэ.

анхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

ендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.

удалдан авах ажиллагааны хууль тогтоомж

нэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

удалдан авах ажиллагааны цахим систем

ендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид "цахим систем" гэх/-ээр зохион байгуулна.

влига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

ахиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

ийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20^1, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад

	хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
онирхогч этгээд, оролцогч	ролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ. ролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна. онгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй. ендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна. ШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
үншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ	ендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна. услан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй. үншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна. ШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй. үншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ. ШЗ-ны 7.1-д заасан гэрээнд түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх үүрэг (тоо хэмжээ гэх мэт)-ийг үнийн дүнгийн хамт тодорхойлж, тусгасан байна.

Б.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМ БИЧГИЙН АГУУЛГА

ендер шалгаруулалтын баримт бичиг	ендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ: I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа; II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт; III Бүлэг. Техникийн тодорхойлолт IV Бүлэг. Тендерийн жишиг маягт; V Бүлэг. Гэрээний нөхцөл

ахиалагч тендер шалгаруулалтын үр дүнд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

удалдан авах барааны онцлогоос хамаарч гэрээний нөхцөлийг V бүлэгт заасан гэрээний нөхцөлөөс өөрөөр тодорхойлох шаардлагатай бол үндэслэлийг дурдаж хуулийн 39.3-т заасанд нийцсэн худалдан авах гэрээний нөхцөлийг баримталж болно.

онирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

ендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах

онирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.

ШЗ-ны 9.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.

одруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэнд тооцно.

ендер ирүүлэхийн өмнөх уулзалт

уулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах (эсхүл ажлын талбайтай танилцуулах) бол өгөгдлийн хүснэгтэд заана.

улзалтад ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

ШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

В.ТЕНДЕР БЭЛТГЭХ

ендер шалгаруулалтын баримт бичиг болон тендерийн хэл

ендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг оролцогч бэлтгэн ирүүлнэ.

өвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-

ны 11.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

ендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 11.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.

ахиалагч ТШЗ-ны 11.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

ендерийн иж бүрдэл

ендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.

ролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

ШЗ-ны 13-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

ролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

гөгдлийн хүснэгтэд зөвшөөрсөн бол ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

ШЗ-ны 15-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

ШЗ-ны 17, 18, 19-д заасны дагуу ирүүлсэн баримт бичиг;

анал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

ШЗ-ны 20.4-т заасан тохиолдолд холбогдох тайлбар;

үншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

ендер шалгаруулалтын баримт бичигт заасан бусад баримт бичиг.

ролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

ролцогч хуулийн 22.10-т заасныг үндэслэн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

ендерийн жишиг маягт

ролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн IV бүлэг дэх жишиг маягтаас аль шаардсан маягтыг дараах байдлаар ирүүлнэ.

уулийн 21.1.3-т заасны дагуу цахим системд үүсгэгдсэн бол цахим системээр ирүүлнэ.

ШЗ-ны 13.1.1-д зааснаас бусад маягтыг тендерт хавсарган ирүүлнэ.

увилбарт санал

гөгдлийн хүснэгтэд заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.

рөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг

ролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг IV бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.

эрэв өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 7.1-д заасан ерөнхий шаардлагыг магадлахтай холбоотой баримт бичгийг ирүүлнэ.

адаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

уулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

адаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

ендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох болон ТШЗ-ны 15.2-т заасанд холбогдох баримт бичиг.

ахиалагч оролцогчийн ерөнхий шаардлагыг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 15.2, 15.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

анал болгож буй үйлчилгээ тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

ролцогчийн санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар ирүүлнэ.

гөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож үйлчилгээний загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилт хийх ажиллагаанд өгөгдлийн хүснэгтэд заасны дагуу оролцоно.

отлох баримт нь нийтлэл, зураг төсөл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас зэрэг тухайн гүйцэтгүүлэх ажлын техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг дурдсан баримт байж болно.

II бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

ахиалагчийн гүйцэтгүүлэх үйлчилгээг дагалдах бараа байгаа бол техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримт бичиг ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 16.1-д зааж болно.

адавхын болон туршлагын шаардлага

ахиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.

үншлэл нь ТШЗ-ны 17.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна.

орлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 17.1-д зааснаар өгөгдлийн хүснэгтэд тусгасан бол түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

йлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

услан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

ролцогч, түүний түншлэлийн гишүүний хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээллийг тендерт ирүүлэхийг шаардах бол өгөгдлийн хүснэгтэд заана.

анхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

анхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.

ролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад

	асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
	гөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 18.1-д заасан тохиолдолд Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
ехникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт	ехникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан болон хуулийн 17.4-т хамаарах баримт бичгийн хүрээнд өгөгдлийн хүснэгтэд заана.
ендерийн үнэ	уулийн 34.8-д заасны дагуу үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад оролцогчийн ирүүлсэн эцсийн үнэ түүний тендерийн үнэ байна.
	ШЗ-ны 20.1-д заасан тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
	ууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
	уулийн 21.5-д заасан тохиолдолд оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
ендерийн валют	ролцогч Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
	онгол Улсын олон улсын гэрээнд зааснаар, эсхүл захиалагч Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1-д заасан Монголбанкнаас олгосон зөвшөөрөлд үндэслэн ТШЗ-ны 21.1-д заасан тендерийн валютыг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
ендер хүчинтэй байх хугацаа	ролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх

хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.

уулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ, ҮНИЙН САНАЛ ДУУДАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ, ТЕНДЕР НЭЭХ

ендер баталгаажуулах, илгээх

ендерийг хуулийн 22.1-д зааснаар тоон гарын үсгээр баталгаажуулж, цахим системээр илгээнэ.

ШЗ-ны 23.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

ролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол IV бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 23.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

ролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг IV бүлгийн Маягт 5-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

уулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 23.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

ендер хүлээн авах эцсийн хугацаа

ендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

нийн санал дуудах ажиллагаа

нийн санал дуудах ажиллагаа хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу явагдана.

ахиалагч хуулийн 34.9-д зааснаар үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад эцсийн үнийг өсөх дараалаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендерийг хянан үзнэ.

нийн санал дуудах ажиллагаа эхлэх, үргэлжлэх хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.

ендер нээх

ахиалагч тендерийн нээлтийг цахим системээр

	өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д.ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

ендер шаардлагад нийцсэн хянан үзэх, үнэлэх	ШЗ-ны 25.2-т зааснаар эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендерийг хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, Сангийн сайдын баталсан аргачлал, зааврын дагуу ТШЗ-ны 12 дугаар зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ. хэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ. гөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
ендерийн талаар тодруулга авах	ендерийг хянан үзэх явцад тодруулга авах шаардлагатай гэж үзвэл хуулийн 25 дугаар зүйлийг баримтална.
ролцогчийн чадавхыг дахин магадлах	ахиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална. ШЗ-ны 29.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19-д заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ. ШЗ-ны 29.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.
ахиалагч шийдвэр гаргах	ахиалагч ТШЗ-ны 28, 29, 30-д заасны дагуу оролцогчийн тендерийг хянан үзэж, хуулийн 28.1-д заасан шийдвэрээс аль тохирохыг гаргаж, оролцогч нарт хүргүүлнэ.
эрээнд гарын үсэг зурж баталгаажуулах	ахиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ. алгарсан оролцогч ТШЗ-ны 31.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагчийн нэр: ***Аймгийн Засаг даргын Тамгын газар Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газар***
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалтын нэр: ***Өвөрхангай аймгийн Хужирт сумын Шивээт 4 дүгээр баг, Шунхлай 5 дугаар багуудад шинээр хийх хатуу хучилттай авто замын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил***
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: ***ӨВАХААГ/20260203034***
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтын багцын тоо болон нэр: ***Байхгүй.***
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтын урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: ***Үгүй***
ТШЗ 1.5	Үйлчилгээний үр дүнд оюуны өмчийн эрхийг захиалагч, түүний этгээд эзэмших эсэх: ***Тийм***
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр*: **Улсын төсвийн хөрөнгө оруулалт***
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: ***70,000,000 (далан сая) төгрөг.***
Б.АГУУЛГА	
ТШЗ 9.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: ***Худалдан авах ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн Т.Эрдэнэсүрэн*** Хаяг: Нутгийн удирдлагын ордон, 5 дугаар давхар, 503 тоот Утасны дугаар: ***70322307*** Цахим шуудангийн хаяг: ***uvprocurement@gmail.com***
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: ***Үгүй***
В.ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 11.2	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэлийг ТШЗ 11.1-д зааснаас өөрөөр заах бол: ***Монгол***
ТШЗ 14.1	Хувилбарт санал ирүүлэхийг: ***"Зөвшөөрөхгүй"***
ТШЗ 15.2	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: Шаардана. 1. Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэл, татварын өр төлбөргүй тодорхойлолт болон шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй талаарх хүчин төгөлдөр лавлагааг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ. Энэхүү тодорхойлолтыг ирүүлээгүй тохиолдолд тендер нээсэн өдрийн байдлаар татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өр төлбөр болон шүүхийн шийдвэрээр өртэй эсэх лавлагааг захиалагч шалгана. (Гадаадын этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан, эсхүл

	оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгүүд, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгүүдийг, орчуулгын хамт ирүүлнэ. Мөн улсын бүртгэлийн гэрчилгээг орчуулгын хамт ирүүлнэ.)
ТШЗ 16.1	Техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлоход шаардах баримт бичиг: ***"Шаардахгүй"***
ТШЗ 16.2	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж шаардах эсэх, шалгалт туршилт зохион байгуулах эсэх: ***"Үгүй"***
ТШЗ 17.4	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: Үйлчилгээ үзүүлэгч нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна. Зам, тээврийн яамны: - 5.2.1. Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, - 5.2.2. Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах (Уг ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн мэдээллийг цахим системээс шалгана. Оролцогч Худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэлтэй өөрийн зөвшөөрлийн талаар мэдээллийг бүрэн, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг шалгах үүрэгтэй.)
ТШЗ 17.6	Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: **"Шаардана"** оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг IV бүлгийн Маягт 3-ын дагуу ирүүлнэ.
ТШЗ 18.1	Санхүүгийн чадавхын шаардлага: Шаардана. 1.Борлуулалтын орлогын хэмжээ: 2023, 2024 онуудын борлуулалтын орлогын нийлбэр нь батлагдсан төсөвт өртгийн 50 хувь болон түүнээс багагүй байна. 2.Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна. 3.Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: ***"Тийм"*** 1.Тендерт оролцогчийн борлуулалтын орлогын мэдээллийг Сангийн яамны санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангаас шалгана. Жич: 2023, 2024 оны санхүүгийн тайлан e-balance цахим бүртгэлд шивэгдэж баталгаажсан байх шаардлагатай, санхүүгийн тайланг e-balance цахим бүртгэлд шивээгүй, баталгаажуулаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. 2.Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээг нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тодорхойлно. Үүнд: -Тендерт оролцогчийн харилцагч банкны дансны үлдэгдэл; -Харилцагч банкнаас авч болох мөнгөн дүн бүхий судлагдсан зээлийн тодорхойлолт ирүүлнэ. (Банкны судлан үзэж зээл олгох боломжтой гэсэн тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй). - Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд. 3.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий "Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт"-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл "Хэвийн" бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл

	болно. (“Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй.) 2023, 2024 онуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг ирүүлнэ.
ТШЗ 19.1	Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг: 1.Ажил гүйцэтгэх хүний нөөцийн шаардлагыг нотлох дараах баримт бичиг ирүүлнэ.

№	Албан тушаал	Ажилтны тоо	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага
1.	Авто замын инженер	1	Автозам, гүүрийн инженер (мэргэшсэн эсвэл зөвлөх зэрэгтэй байх)	Тухайн мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан байх
2.	Хэмжилтийн инженер	1	Авто замын инженер эсвэл геодизийн инженер	Тухайн мэргэжлээрээ 3 ба түүнээс дээш жил ажилласан байх
3.	Мэргэшсэн төсөвчин	1	Мэргэшсэн төсөвчин байх	Тухайн мэргэжлээрээ 3 ба түүнээс дээш жил ажилласан байх

2.Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Шаардахгүй.
3.Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: Шаардана.
Сүүлийн 2 жил буюу 2024, 2025 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх ба батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй байна.
4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: Шаардана.
5.Бусад шаардлага:
- Ажлын даалгаврын дагуу ажлын төлөвлөгөө, графикийг оновчтой төлөвлөсөн байна.
- Санхүүгийн санал боловсруулж ирүүлнэ.

Үүнд: а)Тендерт оролцогчийн үндсэн ажилтан, хөлсөөр ажиллах гэрээний дагуу ажиллах ажилтны мэдээллийг цахим систем дэх V бүлэгт заасан маягтаар зааварчилгааны дагуу санал болгоно. Цахим системээр санал болгоогүй тохиолдолд хянан үзэхгүй. Цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсний нийлүүлэгчийн гарын авлага хэсгээс зааварчилгаатай танилцана уу.

б) Ажилтны сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй, төрийн мэдээлэл, солилцооны ХУР системээр дамжуулан Боловсрол,

	шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. (Тендерт оролцогч нь Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia/-д ажилтны дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг урьдчилан шалгах шаардлагатайг анхаарна уу.) Хэрэв санал болгож буй ажилтан нь гадаад улсад сургууль төгссөн бол дипломын хуулбарыг орчуулгын хамт ирүүлнэ. Мөн төсөвчний мэргэжлийн үнэмлэхийг эх хувиас сканердаж ирүүлэх. в) Тендерт оролцогчийн үндсэн ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн сүүлийн 3 сарын мэдээллийг цахим системээр дамжуулан шалгана. Бусад ажилтны хөлсөөр ажиллах гэрээг зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай. г) Мэргэшсэн, зөвлөх зэрэгтэй ажилтан, төсөвчний хүчин төгөлдөр мэргэжлийн гэрчилгээний хуулбарыг тендерт хавсарган ирүүлнэ. 1.Тухайн ажлын гэрээний гүйцэтгэлд дээрх санал болгосон ажилтнаас өөр ажилтнаар ажил гүйцэтгүүлсэн тохиолдолд илт худал мэдээлэл бүхий тендер гэж үзэн эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах нөхцөл болохыг анхаарна уу. Үүнд: а) Ижил төстэй ажлын туршлагын шаардлагыг хангах ажил гүйцэтгэсэн гэрээ, акт, магадлалын дүгнэлтийг ирүүлнэ. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан зураг төсөл, техникийн нөхцөлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн үйлчилгээг дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. Үйлчилгээ үзүүлэх хуваарийг баталгаажуулан ирүүлнэ. Үйлчилгээ үзүүлэх хугацаа: Хуанлийн 30 хоног хүртэл байна. Шалгарсан оролцогч гэрээт хугацаандаа хүлээлгэн өгөөгүй нөхцөлд гэрээг цуцлах үндэслэл болно. ТӨХ-д шаардсан материалуудын аль нэг ирүүлээгүй, эсхүл өөрөөр ирүүлсэн тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.
ТШЗ 19.1	
ТШЗ 20.3	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: ***“Тохируулахгүй тогтмол байна”.***
ТШЗ 21.2	Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар, эсхүл захиалагч Монголбанкнаас зөвшөөрөл авснаар тендерийн валютыг ТШЗ-ны 21.1-д зааснаас өөрөөр заах бол: ***Төгрөг байна.***
Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ, ҮНИЙН САНАЛ ДУУДАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ, ТЕНДЕР НЭЭХ	
ТШЗ 23.5	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: 1. Ажлын даалгаврыг гүйцэтгэх аргачлалын талаарх танилцуулга 2. Ажлын даалгаврын дагуу үзүүлэх үйлчилгээг гүйцэтгэх хуваарь
ТШЗ 24.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: ***2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр*** Цаг: ***09 цаг 00 минут***
ТШЗ 25.3	Үнийн санал дуудах ажиллагаа эхлэх, үргэлжлэх хугацаа: Огноо: ***2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр*** Цаг: ***09 цаг 00 минут***

ТШЗ 26.1	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: ***2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр*** Цаг: ***09 цаг 30 минут*** Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Өвөрхангай аймгийн Нутгийн удирдлагын ордон 5 дугаар давхар, Худалдан авах ажиллагааны газар, 503 тоот
Д.ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	
ТШЗ 27.3	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: Үгүй.

Үйлчилгээ үзүүлэх хуваарь

[Захиалагч доорх хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, оролцогч 8 дугаар баганыг бөглөнө]

№	Нэр төрөл	Үйлчилгээний талаарх тодорхойлолт	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Үйлчилгээ үзүүлэх газар	Үйлчилгээ үзүүлэх хугацаа	
						Үйлчилгээ хүлээн авах хугацаа	Гүйцэтгэгчийн санал болгох хугацаа *(оролцогч энэ баганыг бөглөнө)*
1	*2*	*3*	*4*	*5*	*6*	*7*	*8*
1	Өвөрхангай аймгийн Хужирт сумын Шивээт 4 дүгээр баг, Шунхлай 5 дугаар багуудад шинээр хийх хатуу хучилттай авто замын нарийвчилсан зураг төсөл боловсруулах		*Авто замны зураг*	*ш*	*Өвөрхангай аймаг Хужирт сум*	*2026 оны 02 дугаар сарын 30*	*[7 дугаар баганад заасан хугацаанд багтаан гүйцэтгэхээр санал болгож буй хугацааг бичих]*
2							
3							
...							

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,

эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга/тэмдэг]:

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Маягтуудын жагсаалт:

Маягт 1: Тендер илгээх маягт 21
Маягт 2: Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл..... 23
Маягт 3: Хэрэгжүүлж буй, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл 23
Маягт 4: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл 23
Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт 24
Маягт 6: Үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн мэдээлэл..... 24
Маягт 7: Үйлчилгээ үзүүлэх ажилтны товч намтар (CV)..... 25

Маягт 1: Тендер илгээх маягт

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]

Манай ***[оролцогчийн нэр]*** нь танай байгууллагаас зарласан ***[тендер шалгаруулалтын нэр, дугаар]*** тендер шалгаруулалтын үнийн санал дуудах ажиллагаанд эцсийн санал болгосон үнээр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлэхээр, доор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид "тендер" гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

ендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.

ролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:

өрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;

өлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;

